

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/11/НА-СТА-ТӨА

ЭРДЭНЭСАНТ АЗЗА ТӨХК-ИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Б.Одбилэг

Утас: 70272287 Цахим хаяг: odbilegb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Компани, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Компанийн гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.4 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗТХЯ	Зам Тээвэр Хөгжлийн Яам
ЗТХТ	Зам тээвэр хөгжлийн төв

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tov@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.15 № 01/2024
Тавай _____ -ны № _____ -т

ЭРДЭНЭСАНТ АЗЗА ТӨХК-ИЙН
ЗАХИРАЛ А.БАЯСГАЛАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Их Хурлын 2002 оны 16 тогтоолоор баталсан Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэлийн 4 дүгээр зүйлийн 4.1-т "Доор дурдсан төрийн өмчит хуулийн этгээдийн 34 хүртэлх хувийн энгийн хувьцааг нэмж гарган Монголын хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй худалдан нээлттэй хувьцаат компани болгоно", 4.1.19-д "Эрдэнэсант АЗЗА ТӨХК" гэж заасан байна.

Аудитын гол асуудал

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 580 дугаар тогтоолоор 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталж, тайлант оны нийт цэвэр ашиг 117,410.6 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 113,194.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний

олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	8,179,614.05	118,111,754.26
1.1.2	Дансны авлага	28,265,536.00	22,188,318.75
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	19,308,425.67	99,398.90
1.1.4	Бусад авлага	7,900,000.00	720,000.00
1.1.6	Бараа материал	36,228,299.14	13,045,131.26
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	99,881,874.86	154,164,603.17
1.2.1	Үндсэн хөрөнгө	531,138,510.31	524,810,077.39
1.2.1.1	Барилга байгууламж	442,039,172.55	442,039,172.55
1.2.1.2	Хуримтлагдсан элэгдэл	65,414,822.13	77,584,402.78
1.2.1.3	Машин тоног, төхөөрөмж	237,717,926.73	237,717,926.73
1.2.1.4	Хуримтлагдсан элэгдэл	135,841,077.43	153,277,670.88
1.2.1.5	Тээврийн хэрэгсэл	668,527,512.18	668,527,512.18
1.2.1.6	Хуримтлагдсан элэгдэл	580,856,831.61	608,419,955.14
1.2.1.7	Тавилга эд хогшил	32,008,460.94	32,008,460.94
1.2.1.8	Хуримтлагдсан элэгдэл	18,040,658.18	21,302,764.38
1.2.1.9	Компьютер, бусад хэрэгсэл	27,067,127.27	27,067,127.27
1.2.1.10	Хуримтлагдсан элэгдэл	19,348,300.01	21,965,329.10
1.2.2	Биет бус хөрөнгө	40,615,369.44	40,607,475.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	571,753,879.75	565,417,552.39
1.3	Нийт хөрөнгийн дүн	671,635,754.61	719,582,155.56
2.1.1.1	Дансны өглөг	332,736,672.34	132,672,585.95
2.1.1.2	Цалингийн өглөг	21,132,852.42	3,014,079.02
2.1.1.3	Татварын өр	76,538,073.07	93,157,326.36
2.1.1.4	НДШ - ийн өглөг	97,427,858.31	120,832,129.76
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	19,685,611.00	128,380,617.93
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	547,521,067.14	478,056,739.02
2.2	Өр төлбөрийн нийт дүн	547,521,067.14	478,056,739.02
2.3	Өмч	1,018,908,828.41	1,018,908,828.41
2.3.1	төрийн	1,018,908,828.41	1,018,908,828.41
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	25,244,498.98	25,244,498.98
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	40,270,000.00	40,270,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-960,608,300.00	-842,897,910.85
2.3.10	Өмнөх үе	-675,851,400.00	-659,307,641.27
2.3.11	Тайлант үе	-284,457,200.00	-183,590,269.58
2.3.12	Эздийн өмчийн дүн	123,815,027.39	241,525,416.54
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	671,336,094.53	719,582,155.56

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	972,030,269.91	1,454,564,136.91
2	Борлуулалтын өртөг	1,029,127,781.78	1,128,554,262.88
3	Нийт ашиг (алдагдал)	-57,097,511.87	326,009,874.03

4	Бусад орлого	52,107,090.91	121,951,394.00
5	Ерөнхий ба удирдлагын зардал	267,391,280.97	295,256,645.38
6	Санхүүгийн зардал	6,382,500.00	0.00
7	Бусад зардал	5,693,060.00	22,248,374.34
8	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-284,457,261.93	130,456,248.31
9	Орлогын татварын зардал	-	13,045,624.80
10	Татварын дараах ашиг (алдагдал)	-284,457,261.93	117,410,623.51
11	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-284,457,261.93	117,410,623.51
12	Орлогын нийт дүн	-284,457,261.93	117,410,623.51

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	1,018,908,828.41	25,244,498.98	40,270,000.00	(960,308,600.0)	123,815,027.39
2	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл				-	-
3	Залруулсан үлдэгдэл	1,018,908,828.41	25,244,498.98	40,270,000.00	(675,851,400)	408,571,949.40
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				241,525,416.55	241,525,416.55
5	Бусад дэлгэрэнгүй орлого		-	-		-
6	Өмчид гарсан өөрчлөлт			-		-
7	Зарласан ногдол ашиг					-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		-			-
9	2023 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	1,018,908,828.41	25,244,498.98	40,270,000.00	(842897910.84)	241,525,416.55

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн	1,135,194,958.00	1,784,152,828.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	477,573,635.00	1,733,152,828.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	46,777.65	0.00

1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	622,830,145.35	0.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	34,744,400.00	51,000,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн	1,192,213,607.21	1,675,135,887.79
1.2.1	Ажиллагчдад төлсөн	396,748,422.77	435,889,649.87
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	149,988,669.93	113,000,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	462,988,715.25	942,846,684.57
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	1,514,981.18	2,657,083.51
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	45,516,489.58	3,210,400.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	2,812,500.00	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	73,457,443.68	94,841,433.82
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	886,875.00	800,250.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	58,299,509.82	81,890,386.20
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-57,018,649.21	109,016,940.21
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний	26,194,100.00	797,600.00
2.1	Мөнгөн орлогын дүн	34,070,000.00	1,517,600.00
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	30,500,000.00	1,517,600.00
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	3,570,000.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн	7,875,900.00	720,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	7,875,900.00	720,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	26,194,100.00	797,600.00
3.1	Мөнгөн орлогын дүн	271,315,000.00	0.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	271,315,000.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн	270,315,000.00	0.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	270,315,000.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,000,000.00	0.00
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-29,824,549.21	109,814,540.21
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	38,004,163.26	8,179,614.05
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	8,179,614.05	118,111,754.26

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2022 оны гүйцэтгэл	2023 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	<u>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт</u>		-	-	-		
	Улсын чанартай зам засварын ажил	мян.төг	979,522.30	1,980,000.00	1,332,612.75	647,387.25	67.3
	Орон нутгийн чанартай зам засварын ажил	мян.төг	69,000.00	90,909.10	121,951.39	-31,042.29	134.1
2	Нийт орлого	мян.төг	1,048,522.30	2,070,909.10	1,454,564.14	616,344.96	70.2
	Үүнээс: Цэвэр борлуулалт	мян.төг	1,048,522.30	2,070,909.10	1,454,564.14	616,344.96	70.2
3	Нийт зардал	мян.төг	1,211,393.50	2,066,693.10	1,308,594.60	758,098.50	63.3
	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	324,066.20	275,577.50	295,256.65	-19,679.15	107.1
4	Татварын өмнөх ашиг	мян.төг	-162,871.20	4,216.00	130,456.25	-	3094.3
5	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	-162,871.20	3,794.40	129,346.79	-	3408.9
6	Төсвийн төлбөрт нийт дүн	мян.төг	185,690.50	281,226.30	250,255.46	30,970.84	89.0
	а/ Орлогын татварт	мян.төг	0.00	421.60	1,109.46	-687.86	263.2
	б/ НӨАТ	мян.төг	76,346.50	146,363.60	114,150.00	32,213.60	78.0
	в/ НДШ	мян.төг	74,695.60	86,399.30	113,000.00	-26,600.70	130.8
	г/ Хүн амын орлогын албан татвар	мян.төг	29,813.90	43,173.80	18,075.40	25,098.40	41.9
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	мян.төг	2,918.00	2,918.00	2,616.70	301.30	89.7
	е/ Гаалийн татвар	мян.төг	0	0	0	0.00	0.0
	ж/ Тээврийн хэрэгслийн татвар	мян.төг	1,029.70	1,050.00	1,029.70	20.30	98.1
	з/ Бусад татварт	мян.төг	886.80	900	274.2	625.80	30.5
7	Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг	0	758.90	0	758.90	0.0
8	Нийт ажиллагсдын тоо	Хүн	41	41	37	4.00	0.0
9	Нийт цалингийн сан	мян.төг	515,142.30	595,857.20	550,160.50	45,696.70	92.3
	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	мян.төг	1.16	1	1.25	-0.25	125.0
11	Хөрөнгө оруулалт	мян.төг	0	80,000.00	0	80,000.00	0.0
12	Нийт авлага	мян.төг	25,085.90	19,085.00	22,188.30	-3,103.30	116.3
13	Нийт өглөг	мян.төг	546,650.70	150,000.00	465,011.11	-	310.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани/ТӨҮГ, түүний үйл ажиллагаа

Эрдэнэсант АЗЗА ТӨХК нь эрхэм зорилгоо “Төрийн захиргааны төв байгууллагаас баталгаажуулсан улсын чанартай авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтыг хариуцсан замын хэмжээнд зохион байгуулж, түүгээр өнгөрч байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг жилийн 4 улирлын туршид бүрэн хангах” гэж тодорхойлсон.

Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ний дүрэм, тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Авто зам, замын байгууламжийн засвар, арчлалт
- Хатуу хучилттай авто зам барих
- Хайрган хучилттай авто зам барих
- Бүх төрлийн гүүр, туннель, газар доогуур нүхэн гармын арчлалт, урсгал засвар, ээлжит засварын ажил
- Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн өмчит хувьцаат компани статустай байна.

Төрийн өмчийн хорооны 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 437 дугаар тогтоолоор Улаанбаатар АЗЗА ТӨХК-аас тусгаарлан байгуулсан байна.

3.2 Компани/ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин

Авто замын тухай хуулийн 23 дуугаар зүйлийн 23.1-д “Авто замын ашиглалт, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, арчлалт, урсгал засварын ажлыг тогтмол гүйцэтгэх чиг үүрэг бүхий зам хариуцагч байгууллага байна. Зам хариуцагч байгууллага нь замын арчлалт, засварын ажлыг гүйцэтгэх тусгай зөвшөөрөл бүхий төрийн болон хувийн өмчит хуулийн этгээд байна” гэж заасны дагуу үйл ажиллагаа явуулдаг ЗТХЯ-ны харьяа байгууллага юм.

Компани 100 хувь төрийн өмчит хувьцаат компани бөгөөд хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар хэрэгжүүлдэг. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 390 дүгээр тогтоолоор ТУЗ-ийн даргыг томилсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Засгийн газрын 2022 оны 203 дугаар тогтоол “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тогтоол “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын баталсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу тус байгууллагын 2022 оны удирдлага, санхүү аж ахуй, эдийн засгийн үйл ажиллагаанд, Төв аймгийн Санхүү хяналт, дотоод аудитын албаны 2023 оны санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөө, аймгийн Засаг дарга бөгөөд дотоод аудитын хорооны даргын баталсан 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 33/50 дугаар удирдамжийн дагуу 2022 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд тус тус дотоод хяналт шалгалт хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 47,946.4 мянган төгрөгөөр буюу 7,1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	8,179.61	118,111.75	109,932.14
Авлага	28,265.54	22,188.32	-6,077.22
Бараа материал	36,228.30	13,045.13	-23,183.17
Урьдчилж төлсөн зардал	0.00	0.00	0.00
Дуусаагүй үйлдвэрлэл	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгө	571,753.88	565,417.55	-6,336.33
Нийт хөрөнгө	671,635.75	719,582.16	47,946.40
Өр төлбөр	547,521.07	478,056.74	-69,464.33
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	123,815.03	241,525.42	117,710.39
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	671,336.09	719,582.16	48,246.06

Дээрх хүснэгтээс харахад, мөнгөн хөрөнгө, бараа материал, эздийн өмчийн дансны үлдэгдэл өмнөх оноос өсөж, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн дансны үлдэгдэл өмнөх оны үзүүлэлтээс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 109,932.14 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны эцэст өвлийн зам засвар арчлалтын санхүүжилт шилжүүлж, зарцуулагдаагүй үлдсэн нь нөлөөлсөн байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 23,183.17 мянган төгрөгөөр буурсан нь 598,526.0 мянган төгрөгийн хангамжийн материал бэлтгэн, 609,666.97 мянган төгрөгийн материалыг зарцуулсан нь нөлөөлсөн байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,336.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардал нөлөөлсөн байна.
- Авлагын дансны үлдэгдэл 6,077.2 мянган төгрөгөөр буурсан нь ажиллагсдаас

авах авлагаа барагдуулсантай холбоотой байна. 2019 онд Булган сэцэд ХХК-д гэрээгээр ажил гүйцэтгэсэн боловч гэрээний дагуу төлбөрийг барагдуулаагүй 22,188.3 мянган төгрөгийн авлагатай байна.

- Өр төлбөрийн үлдэгдэл 69,464.3 мянган төгрөгөөр буурсан боловч нийгмийн даатгалын шимтгэл 23,404.27 мянган төгрөгөөр, татварын өр 16,619.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.
- Эздийн өмчийн дансны үлдэгдэл 117,710.39 мянган төгрөгөөр өссөн нь оны эцэст Зам тээвэр хөгжлийн яамнаас гүйцэтгэсэн ажлын санхүүжилт болох 221,023.5 мянган төгрөгийг шилжүүлснээс шалтгаалсан байна. Нийт 117,710.39 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Эрдэнэсант АЗЗА ТӨХК нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 580 дугаар тогтоолоор 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 2,070,909.1 мянган төгрөгөөр, нийт зардлыг 2,066,693.1 мянган төгрөгөөр, 4,216.0 мянган төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 80,000.0 мянган төгрөгийг төлөвлөсөн байна.

Эрдэнэсант АЗЗА ТӨХК нь гүйцэтгэлээр 1,454,564.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,337,152.9 мянган төгрөгийн зардал гарган, 130,456,25 мянган төгрөгийн татварын өмнөх ашиг, 117,410.39 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ийн нийт орлогын гүйцэтгэл 1,454,564.1 мянган төгрөг болж төлөвлөснөөс 616,344.96 мянган төгрөг буюу 30,8 хувиар дутуу биелүүлсэн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 2,066,693.10 мянган төгрөг төлөвлөснөөс 742,585,21 мянган төгрөг буюу 35,9 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь орлогын төлөвлөгөөний биелэлтэй шууд уялдаатай байна.

Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 80,000.0 мянган төгрөг төлөвлөсөн боловч гүйцэтгэл гараагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх Эрдэнэсант АЗЗА ТӨХК түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилготой холбоотой хөрөнгө данс бүртгэлд тусгах асуудлыг холбогдох газраар шийдүүлэх, түрээсийн орлого, өр төлбөрийг барагдуулахтай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Одбилэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ийн 2022 оны орлого үр дүнгийн тайлан, суурь үзүүлэлтийг 972,030.3 мянган төгрөгийн нийт орлогоор сонгож, материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоон сонгосон суурь үзүүлэлтээс тооцож, төлөвлөлтийн материаллаг байдлыг 14,580.4 мянган төгрөгөөр тогтоож баримтжууллаа.

Санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 10,935.3 мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв АЗЗА ТӨХК тайлант онд 41 орон тоотой ажиллахаас 37 орон тоогоор ажиллаж цалин, НДШ-ийн зардлыг 29,700.0 мянган төгрөгөөр, дотоод албан томилолт, гар утасны ярианы төлбөрт зардал гаргаагүй ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд 157 мэдээлэл байршуулахаас 144 мэдээллийг хугацаанд, 1 мэдээллийг хугацаа хоцроож, 12 (Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг) мэдээллийг байршуулаагүй зөрчил байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.8-д "... хөрөнгө, мөнгө зарцуулах, ... шийдвэр", гэсэнтэй нийцэхгүй байгаа тул албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ийн 2023 оны эхний хагас жилийн баримтад завсрын аудит хийж, аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Эрдэнэсант АЗЗА ТӨХК 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 4 албан шаардлагыг 100% хэрэгжүүлэн Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2023 оны 6 дугаар сарын 9-ны өдрийн 63 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	4	245,479.5	4	245,479.5	100
Зөвлөмж					
Нийт дүн	4	245,479.5	4	245,479.5	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 29,559.2 мянган төгрөгийн алдааг залруулж илэрснээс, 1,750.0 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж ажиллав.

5.1 Залруулсан алдаа

1.Илрүүлэлт: Санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн уялдааг тулгаж үзэхэд тайлант оны эхний үлдэгдэл 16,513.6 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2.Илрүүлэлт: Тайлант жилд ногдуулсан ААНОАТ-ын 13,045.6 мянган төгрөгийг санхүүгийн тайлан тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

5.2 Албан шаардлага

1.Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд 157 мэдээлэл байршуулахаас 144 мэдээллийг хугацаанд, 1 мэдээллийг хугацаа хоцроож, 12 мэдээллийг байршуулаагүй зөрчил байна

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.8-д "... хөрөнгө, мөнгө зарцуулах, ... шийдвэр", гэсэнтэй нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл, зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

2.Илрүүлэлт: Цалин санг нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд зөрүүтэй тайлагнасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар зарцуулах" гэсэн заалтууд болон санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх", "эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл, зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 6 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил				Үүнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Төлбөрийн акт	Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Тоо	Дүн
Шилэн дансны мэдээллийг 1 мэдээллийг хугацаа хоцроож, 12 мэдээллийг огт байршуулаагүй байна.	1				1	-		
Цалин санг нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд зөрүүтэй тайлагнасан.	1	1,750.0			1	1,750.0		
Дүн	2	1,750.0			2	1,750.0		

